



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 410

Улаанбаатар хот

Өмнөговь аймгийн орон нутгийн өмчөөс
2019 онд хувьчлах эд хөрөнгийн
жагсаалтын тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Өмнөговь аймгийн орон нутгийн өмчөөс 2019 онд хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг хавсралтын ёсоор дэмжсүгэй.


2. Жагсаалтад заасан эд хөрөнгийг хувьчлах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу зохион байгуулж, дүнг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2019 оны 4 дүгээр улиралд багтаан танилцуулахыг Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Наранбаатарт зөвлөсүгэй.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

З.МЭНДСАЙХАН

А.АРИУНБОЛД



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн
410 дугаар тогтоолын хавсралт

Өмнөговь аймгийн орон нутгийн өмчөөс 2019 онд хувьчлах эд хөрөнгө

д/д	Хувьчлах эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн олж авсан арга, хэлбэр, эрхийн акт, дугаар он сар өдөр	Байршил, Харьяалал	Хувьчлах эд хөрөнгийн үйл ажиллагааны чиглэл, үл хөдлөх хөрөнгийн зориулалт	Хувьчлагдах эд хөрөнгийн дүн /ААН бол нийт хөрөнгөөс өр төлбөр хассан дүнгээр, үл хөдлөх хөрөнгө бол балансын үлдэгдэл үнэ/ /мян.төг/	Хувьчлах хугацаа	Хувьчлах арга, хэлбэр
1	Эмийн сангийн барилга	УИХ-ын 1999 оны 29 дүгээр тогтоол	Цогт-Овоо сум "Аврах говь" ОНӨААТҮГ	Эмийн сан, орон сууц	-	IV улиралд	Нээлттэй дуудлагын худалдаа
2	Автомашинны гараажийн барилга /7 автомашин/	УИХ-ын 1999 оны 29 дүгээр тогтоол	Мандаг-Овоо сум Засаг даргын Тамгын газар	Автогарааж	7,091.60	IV улиралд	Нээлттэй дуудлагын худалдаа
3	Орон сууцны барилга	УИХ-ын 1999 оны 29 дүгээр тогтоол	Гурвантэс сум Эрүүл мэндийн төв	Орон сууц	638.6	IV улиралд	Орон сууц хувьчлах хуулийн дагуу эзэмшигчид нь үнэ төлбөргүй хувьчлах